



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 273

Улаанбаатар хот

“Санхүүгийн зохицуулах хорооны хуралдааны дэг”-д  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 7.2 дахь хэсгийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийн 4.5, 5.1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 4.5.12<sup>1</sup>, 5.1.2<sup>1</sup> дахь заалтыг тус тус нэмсүгэй.

1/4 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 12<sup>1</sup> дэх заалт:

“4.5.12<sup>1</sup>. Хуралдааны явцад Хорооны дарга, гишүүн Ажлын албанд тодорхой үүрэг өгөхөөр санал гаргасан тохиолдолд тухайн саналаар хуралдаанд оролцсон гишүүдээр санал хураалгах бөгөөд олонх нь дэмжсэн тохиолдолд тухайн үүргийг Хуралдаанаас өгсөн үүрэг гэж үзнэ”.

2/5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2<sup>1</sup> дэх заалт:

“5.1.2<sup>1</sup> Хуралдаанаас өгсөн үүргийг хуралдааны тэмдэглэлээр хэлбэржүүлэх бөгөөд түүнийг энэ дэгийн 5.1.1-д заасан журмаар ёсчилно.


2. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийн 5.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“5.3. Хуралдааны тэмдэглэл хөтөлсөн ажилтан ажлын 5 хоногийн дотор хуралдааны тэмдэглэлийг бичиж гарган гишүүдээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.

3. Тогтоолоор батлагдсан өөрчлөлтийг тус дэгд оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН